



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 53

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арваннэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 720,000 /долоон зуун хорин мянга/ төгрөгийн балансын үнэтэй, 432,000 /дөрвөн зуун гучин хоёр мянга/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 2-р хоолны тогоог аймгийн Нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.


2. Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлгийн дарга (Х.Чирчинсүрэн), аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга (Х.Жаргал) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгө шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  СОД ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
53 дугаар тогтоолын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	2-р хоолны тогоо	2018	литр	100	1	720,000	432,000	288,000
Дүн						720,000 /долоон зуун хорин мянган/ төгрөг	432,000 /дөрвөн зуун гучин хоёр мянга/	288,000 /хоёр зуун наян найман мянган/ төгрөг